



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Налайх дүүргийн “Чандмань Налайх”
ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй барилгыг
акталж, данс бүртгэлээс хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 204 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй нийт 4,114,239,541.38 (дөрвөн тэрбум нэг зуун арван дөрвөн сая хоёр зуун гучин есөн мянга таван зуун дөчин нэгэн төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан орон сууцыг актлан, данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын
даргын 2022 оны 02 дугаар сарын 07
-ний өдрийн А/24 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	60 айлын орон сууц 70 дугаар байр	52	1969	ш	60	1,049,220,000.00	852,491,250.00	196,728,750.00
2	56 айлын орон сууц 71 дүгээр байр	49	1972	ш	56	982,270,767.70	748,981,460.37	233,289,307.33
3	60 айлын орон сууц 72 дугаар байр	53	1968	ш	60	1,049,220,000.00	869,978,250.00	179,241,750.00
4	59 айлын орон сууц 73 дугаар байр	52	1969	ш	59	1,033,528,773.68	839,742,128.61	193,786,645.06
Нийт						4,114,239,541.38	3,311,193,088.98	803,046,452.39